



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 32

Мандалговь

Х.Дашнямыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Хатанбаатар овогтой Дашням 54.4 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Х.Дашнямын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



**Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж  
ахуйн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд  
нэр дэвшүүлсэн Х.Дашнямын тухай дүгнэлт**

1. Х.Дашням нь 1998 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 24 настай, эрэгтэй
2. Боловсрол: 2015-2019 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг зоо инженер, технологи мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Х.Дашнямын тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ

